

2015 ОНЫ ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Ховд аймгийн хэмжээнд 2015 онд 498 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 141 хэргээр буюу 39,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтэнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 98 хэрэг бүртгэгдсэнээс 67 хэргийг нөхөн илрүүлсэн нь нөхөн илрүүлсэн хэрэг 19 хэргээр буюу 39,5 хувиар өсч, гэмт хэргийн илрүүлэлт 68,4 хувьтай байгаа нь улсын дунджаас 8,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гарсан гэмт хэргийг өнгөөр нь урьд оны мөн үетэй харьцуулан авч үзвэл:

Бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 208 бүртгэгдсэн нь 72 хэргээр буюу 52,9 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 125 бүртгэгдсэн нь 29 хэргээр буюу 30,2 хувиар, үүнээс: хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 83 бүртгэгдсэн нь 33 хэргээр буюу 66,0 хувиар, бусдын эд хөрөнгө залилан мэхлэх хэрэг 18 бүртгэгдсэн нь 10 хэргээр буюу 2,2 дахин, бусдын эд хөрөнгө завшиж үрэгдүүлэх 9 хэрэг бүртгэгдсэн нь 7 хэргээр буюу 4,5 дахин, танхайрах 16 хэрэг бүртгэгдсэн 13 хэргээр буюу 5,3 дахин, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах хэрэг 4 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 100 хувиар, захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 8 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 33,3 хувиар, албан тушаалын гэмт хэрэг 4 бүртгэгдсэн нь 3 хэргээр буюу 4 дахин, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих 5 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 25 хувиар тус тус өсчээ.

Бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 2 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 100 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 34 бүртгэгдсэн нь 9 хэргээр буюу 20,9 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 50,0 хувиар, ан агнуурын хууль тогтоомж зөрчих 3 бүртгэгдсэн нь 4 хэргээр буюу 57,1 хувиар, ТХХАБАЖЭ гэмт хэрэг 48 бүртгэгдсэн нь 9 хэргээр буюу 15,7 хувиар тус тус буурсан байна.

Өмнөх оны мөн үед бүртгэгдээгүй хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг 1, хүчиндэх хэрэг 3, авто тээврийн хэрэгсэл хулгайлах 4, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах-1, шүүн таслах ажиллагааны эсрэг 2 тус тус бүртгэгдсэн байна.

Хүнийг санаатай алах хэрэг-1, булаах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Согтуугаар үйлдэгдсэн хэрэг 132 бүртгэгдсэн нь 33 хэргээр буюу 33,3 хувиар, эмэгтэй хүн оролцсон хэрэг 55 бүртгэгдсэн 12 хэргээр буюу 27,9 хувиар, хүүхэд оролцсон хэрэг 18 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 12,5 хувиар, бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 42 бүртгэгдсэн нь 16 хэргээр буюу 61,5 хувиар тус тус өссөн байна.

Өмнөх оны мөн үед бүртгэгдээгүй гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 28, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн 1 хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

Галт зэвсгээр үйлдэгдсэн хэрэг 2 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 33,3 хувиар буурсан байна.

Хэрэг гарсан цаг хугацаа, гараг

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 81 нь Даваа гаригт гарсан нь өмнөх оны мөн үеэс 20 хэргээр буюу 20,8 хувиар, 92 нь Мягмар гаригт гарсан нь 55 хэргээр буюу 148,6 хувиар, 65 нь Пүрэв гаригт гарсан нь 14 хэргээр буюу 27,4 хувиар, 69 нь Баасан гаригт гарсан нь 18 хэргээр буюу 35,2 хувиар, 51 нь Бямба гаригт гарсан нь 7 хэргээр буюу 15,9 хувиар, 76 Ням гарагт гарсан нь 36 хэргээр буюу 90 хувиар тус тус өсч, 64 нь Лхагва гаригт гарсан нь 1 хэргээр буюу 1,5 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

06-14 цагт 115 хэрэг гарсан нь 42 буюу 57,5 хувиар, 14-19 цагт 132 хэрэг гарсан нь 12 буюу 10 хувиар, 19-22 цагт 81 хэрэг гарсан нь 11 буюу 15,7 хувиар, 22-06 цагт 170 хэрэг гарсан нь 76 буюу 80,8 хувиар тус тус өссөн байна.

Гарсан гэмт хэргийн улмаас учирсан хохирол:

Гэмт хэргийн улмаас иргэд аж ахуйн нэгжид 856,9 сая төгрөгийн хохирол учирсанаас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад 68,3 хувь буюу 586,1 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн улмаас 234 хүн гэмтсэн нь 77 хүнээр буюу 49,0 хувиар өсч, гэмт хэргийн улмаас 18 хүн нас барсан нь 2 хүнээр буюу 10,0 хувиар буурсан байна.

Гэмт хэрэг үйлдэгчдийн тухай:

Гэмт хэрэгт 469 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 165 хүнээр буюу 56,3 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 54 буюу 11,5 хувийг эмэгтэй хүн эзлэж байна.

Гэмт хэрэг үйлдэгчдийг насны ангиллаар нь авч үзвэл 15 хүртэл насны 8, 16-17 насны 15 хүн, 18-24 насны 87 хүн, 25-29 насны 106 хүн, 30-34 насны 79 хүн, 35-39 насны 60 хүн, 40-44 насны 53 хүн, 45-49 насны 35 хүн, 50-54 насны 17 хүн, 55-59 насны 4 хүн, 60-64 насны 4 хүн, 70-аас дээш насны 1 хүн хэрэгт холбогдон шалгагдав.

Хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн өргөдөл гомдол мэдээллийн тухай

Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас 6130 гомдол мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 720 гомдол мэдээллээр буюу 13,3 хувиар өсч, 1382 буюу 22,5 хувийг гэмт хэргийн шинжтэй, 2527 буюу 41,2 хувь нь захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзлэж байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийн 416 буюу 6,7 хувийг газар дээр нь очиж зохицуулж, 1131 буюу 18,4 хувьд нь зөвлөгөө өгч, 357 буюу 5,8 хувийг албадан саатуулах байранд шилжүүлж, 285 буюу 4,6 хувь нь гомдол мэдээллийн дуудлага худлаа байсан.

Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн 487 буюу 35,2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 894 буюу 64,6 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Шалгаж шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн 962 буюу 69,6 хувийг 5 хоногт, 420 буюу 30,9 хувийг 6-19 хоногт шалгаж шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаархи гомдол мэдээллийн 1181 буюу 46,7 хувийг шийтгэврээр, 723 буюу 28,6 хувийг торгуулийн хуудсаар торгож, 210 буюу 8,3 хувийг 7-30 хоногийн хугацаагаар баривчилж, 408 буюу 16,1 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч шийдвэрлэсэн байна.

Шалгаж шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээллийн 2506 буюу 99.1 хувийг 14 хоногт, 21 буюу 0.8 хувийг 15-28 хоногт шалгаж шийдвэрлэсэн байна.

2015 онд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн зөрчил гаргасан 2478 хүн саатуулагдсан нь өмнөх оны мөн үеэс 657 хүнээр буюу 20,9 хувиар буурсан байна.

Зөрчил гаргасан 7883 иргэн, 10 аж ахуй нэгж байгууллагад нийт 84,931,900 мянган төгрөгийн торгууль ногдуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон удаа дараа эрүүлжүүлэгдсэн, жижгээр танхайрсан зөрчилд 245 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 309 жолоочийн эрхийг хасах арга хэмжээ авчээ.

ХОВД ЦАГДААГИЙН ГАЗАР